

ГЭР БҮЛТЭЙ АЖИЛЛАХ НИЙГМИЙН АЖИЛ ДАХЬ ГЭР БҮЛИЙН ХАМТЫН СЭТГЭЛ ЗАСЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Т.Бүрэнжаргал
Социологийн ухааны доктор (PhD)

Нийгэм-эдийн засгийн өөрчлөлтийн өнөө үед гэр бүлийн нийгэмд эзлэх байр суурь, түүний бүтэц, үүрэг, гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцаанд үлэмж өөрчлөлтүүд гарч байна. Гэр бүлийн дотор тэгш эрхийн харилцаа ноёрхох болсноор янз бүрийн зөрчил маргааныг уламжлалт сэтгэлгээ, аргаар шийдвэрлэх боломжгүй болжээ. Хотжилт, үйлдвэржилт, шинжлэх ухаан техникийн хөгжлийн өнөө үед хүмүүсийг сэтгэлзүйн дарамт стресст оруулах явдал их болсон байна.

Иймд гэр бүл өөрөө сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх анхдагч орчин болдгийн хувьд гишүүддээ сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлэх шаардлага тулгарна. Барууны судлаачид гэр бүлийн гишүүдийн нэг нэгэндээ үзүүлэх сэтгэл заслын үүргийг хоёр хэсэгт хувааж үздэг. Нэгдүгээрт, тайвшруулах үүрэг буюу хүмүүсийн энгийн харилцааны хэсэг болох илэн далангүй, үр дүнтэй ярилцлагын үр дүнд гишүүнийхээ байр суурийг тодорхойлж, туслан дэмжиж болдог. Хоёрдугаарт, урамшуулан зоригжуулах үүрэг буюу тухайн хүндрэлтэй асуудлыг зөв үнэлэн дүгнэж өөрийн үзэл бодлыг бий болгоход тусалдаг.

Гэр бүлийн гишүүд нэг нэгэндээ сэтгэл заслын үйлчилгээ үзүүлдэг боловч энэ үүргээ гүйцэтгэж чадахаа болих эсвэл огт байхгүйгээс бэрхшээлтэй асуудалд орсон үедээ гэр бүлүүд мэргэжлийн байгууллагад хандах болдог. Гэр бүлд суурилсан сэтгэл заслын үйлчилгээ нь гэр бүлийн гишүүдийг тус тусад нь салангид байдлаар авч үзэхийн оронд бүх гишүүдэд чиглэсэн халамж, туслалцаа үзүүлэх мэргэжлийн үйлчилгээ байдаг юм. Гэр бүлийн мэргэжлийн сэтгэл засалч үйлчилгээг хэд хэдэн бүлэгт чиглүүлэн хүргэдэг. Үүнд:

1. Гэр бүлтэй дам болон шууд холбоотой асуудалтай гэр бүлийн ганц гишүүнд;
2. Гэр бүлийн хосуудад дангаар;
3. Эцэг эх, үр хүүхдүүдэд хамтад;
4. Үр хүүхдүүдэд дангаар;
5. Гэр бүлийн бүх гишүүдэд хамтад нь зэрэг болно.

Гэр бүлийн сэтгэл заслын арга анх 1950 -иад оноос эрчимтэй хөгжих болжээ. Гэр бүлтэй ажиллах нийгмийн ажлын нэг чухал хэсэг бол гэр бүлийн бүх гишүүдийг оролцуулсан хамтын сэтгэл заслын арга юм.²⁶¹ Ж.Белла, В.Сатир, Р.Спек, А.Ферейра, Ж.Бинг-Холл, С.Минучин нарыг энэхүү аргын үндсэн төлөөлөгчдөөр тооцдог.²⁶²

Гэр бүлийн хамтын сэтгэл заслын үндэс нь гэр бүлийн нийгэм- сэтгэл зүйн асуудал болон түүнийг шийдвэрлэхэд гэр бүлийг нэгдмэл цогц зүйл хэмээн үзэх явдал юм. Гэр бүлийн аливаа асуудал гишүүн бүрт сөргөөр нөлөөлж эхэлснээр гэр бүлийн сэтгэл засалч, нийгмийн ажилтанд хандахад хүргэдэг. Бэрхшээлтэй асуудал нь гэр бүлийн гишүүдийн (эцэг эх, өвөө эмээ, бага, өсвөр болон ахлах насны хүүхдүүд) зан чанар, амьдралын хэв маягаас хамааран хүн болгонд янз бүрээр тусч байдаг билээ. Гэр бүлийн асуудлыг үл шийдвэрлэснээр нэг талаас, гэр бүлийн нэгдмэл байдалд цав гаргах, нөгөө талаас, гишүүдийн хувийн зан чанарт өөрчлөлт оруулах хор хөнөөлтэй. Гэр бүлд суурилсан хамтын сэтгэл заслын үйлчилгээг гэр бүл бүхэлд нь чиглүүлж ажилласнаар гэр бүл эрүүл саруул оршин тогтнох үндсийг бэхжүүлж, гишүүдийн хоорондын харилцааг илүү нээлттэй болгож чадна. Гэхдээ гэр бүлийн хамтын сэтгэл заслын аргыг тусламж шаардлагатай гэр бүл болгонд хэрэглэдэггүй, тодорхой хүрээ хязгаартай байдаг. Гишүүд өөр хоорондоо ойр дотно харилцаатай

261 Гэр бүлийн хамтын сэтгэл засал- conjoint family therapy- совместная психотерапия семьи

262 Bell J. Family group therapy. Washington. 1961; Satir V. Conjoin & family therapy. London. 1978; Conjoint therapy theory: Condor book. Paloalto 1967; R.Speck. Bry.A.Inside psychotherapy.NY.1972; A.Ferreira. Family myth and homestasis // ARCH. Gen. Psychiatry. 1963. №9. J.Byng-Hall. Family mythes as defence in conjoint therapy // British journal of medical psychology. 1973. V. 4. №3-4. S.Minuchin. Families and family therapy. London. 1974)

байсан гэр бүлд энэ аргыг хэрэглэвэл үр дүнтэй байдаг бол хүйтэн хөндий уур амьсгалтай гэр бүлийн гишүүд нийгмийн ажилтанд хандахаас татгалзах эсвэл нэгтгэх оролдлогыг эсэргүүцэх үйлдлийг үзүүлдэг.

Гэр бүлийн хамтын сэтгэл заслын үйлчилгээнд гэр бүлийн насанд хүрсэн гишүүд болон хүүхдүүд оролцоно. Гэхдээ 8-14 насны хүүхдүүд байвал илүү үр дүнтэй байдаг. Энэ насны хүүхдүүд гэр бүлийн аливаа асуудлыг тунгаан бодох, дүгнэн эргэцүүлэх чадвартай болсон байдаг. 14-өөс дээш насны өсвөр үеийнхэн гэр бүлийн тогтвортой харилцааг сэргээхийн оронд биеэ даах сонирхолтой байдгаас сэтгэл заслын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдоггүй онцлогтой. Харин 11-13 насны хүүхдүүд гэр бүлийн нэгдмэл харилцааг үгүйлж, гэр бүлд өөрийгөө илэрхийлэн нээх хэрэгцээтэй тулгарч байдгаас гэр бүлийн хамтын сэтгэл заслын үйлчилгээнд идэвхтэй хамрагдана.

Гэр бүлийн нэгдмэл байдлыг илэрхийлж буй мэт боловч зөрчилт харилцааг агуулж байдгийг гишүүдийн хэл яриа, дүгнэлтээс мэдэж болно. Гэр бүлийн сэтгэл засалд "гэр бүлийн домог" хэмээх ойлголтыг А.Ферейра, Ж.Бинг-Холл оруулж иржээ. Гэр бүлийн гишүүдийн харилцан тохиролцсон гаж үүргүүдийн нэгдлээр нөхцөлдөж буй харилцааг гэр бүлийн домог гэнэ. Гэр бүлийн домог нь нийгэмд үзүүлэх элдэв сөрөг нөлөө багатай хирнээ тухайн гэр бүлийн дотоод уян хатан шинж чанарыг үгүй хийдэг. Гэр бүлийн домогт тулгуурлаж оршдог гэр бүл эмзэг зөрчилт систем болж хувирна. Домогт тулгуурлаж буй гэр бүлийн тухай жишээ татан авч үзье.

Эцэг эх, охин, хүүтэй гэр бүл. Гэр бүлийн бүх гишүүд тэгш эрхтэй. Аль нэгийгээ үл ялгана. Бүх хангамжийг тэгш хуваарилдаг. Гэр бүлийн гол зарчим нь нөхөрлөл. Нэг нэгнийхээ төлөө бүгд санаа тавина. Бүх эд юмс, хувцас хунар, хоол хүнсийг гишүүдийн дунд яг ижил хуваана. Бүгд зурагт үзэх тодорхой цагийн хуваарьтай. Гэр бүлийн аль нэг гишүүнд нэн яаралтай хэрэгцээ гарснаас үл хамааран мөнгөн орлогыг тэнцүү хуваарилна. Мөнгөн дэмжлэг хүртэх хүртлээ хүү уранхай гуталтайгаа явдаг.

Гэр бүлийн домгийг гаднаас нь харахад сэтгэл татам аз жаргалтай гэр бүлийн дүр зураг харагдана. Нийгэм- сэтгэлзүйн хувьд зөв мэт энэхүү байдлын цаана нууцлагдсан гэр бүлийн асуудал оршиж байдаг. Дээрхи гэр бүлийн тэгш эрхт харилцаа үлэмж өвөрмөц шинжтэй, өөрөөр хэлбэл, ёс төдий өнгөц тэгш эрх тогтож байгааг харж болно. Гэр бүлийн гишүүдийн хооронд харилцан ойлголцол, хайр хүндлэл, халуун дотно уур амьсгал алга. Гэр бүлийн дотны гэхээсээ албаны харилцаа ноёрхож байв. Гэр бүлийн гишүүд домогт баригдан захирагдаж чадахаа больж, нэг нэгэндээ гомдох болсноор нийгмийн ажилтанд ханджээ. Гэр бүлийн домог үүсэх болсон шалтгааныг нөхөр нь өөр хүүхэнтэй харилцаатай болж хэсэг хугацааны дараа гэр бүлдээ эргэж ирсэнтэй холбоно. Эх, охин, хүү нар санаа их зовно. Эцэг эргэж ирсэн ч гомдол хэвээр үлдэнэ. Энэ тухай дахин ярихгүй байхаар тохиролцож гэр бүлийн гишүүдийн харилцааг нөхөрсөг, тэгш эрхт байдлаар далдлахаар болжээ. Үүнээс гадна охин нь хүнд өвчтэй байсан учир илүү халамж анхаарал тавих шаардлагатай байсан боловч хүүг гомдоохгүйн тулд охин хүү хоёрт бүх зүйлийг тэгш хуваарилдаг байв.

Гэр бүлийн домог нь шийдвэрлэгдээгүй хямралтай асуудлын хөрсөн дээр бүрэлдэн боловсордог ч гэр бүлийг тодорхой хугацаанд гомеостази²⁶³ хүргэдэг. Гэр бүлийн гишүүдийн хооронд үл ойлголцох орчин бүрэлдэж улмаар үүнийгээ далдлах зорилгоор домгийг бий болгоно.

Гэр бүлийн домгийн хандлагыг баримтлагчид гэр бүл болгон ямар нэг эсрэг эсвэл эерэг домгийг агуулж байдаг хэмээн үзнэ. Тиймээс Ж.Бинг-Холл, А.Ферейра нар гэр бүлийн сэтгэл заслын үйлчилгээний үр дүнд хуучин домгийг устгаж шинэ эерэг домгийг бүрэлдүүлэх боломжтой болно гэж үздэг.

Гэр бүлийн хамтын сэтгэл засалд тухайлсан үйлчлүүлэгч (Identified patient) хэмээх ойлголт өргөн хэрэглэгдэнэ. Жишээ нь: гэр бүлийн гишүүд аливаа асуудлын шалтгааныг тухайлсан үйлчлүүлэгчтэй холбодог боловч үнэн хэрэгтээ бүх бэрхшээлүүд зөвхөн түүнтэй холбоотой байдаггүй юм. Тухайлсан үйлчлүүлэгч нь ихэвчлэн хүүхэд болж байдаг.

Тухайлсан үйлчлүүлэгчтэй төсөөтэй "золигт гарах хүн" хэмээх ойлголтын тухай С.Минучин, Р.Спек нар авч үзжээ. "Золигт гарах хүн"-д гэр бүлийн бүхий л нүгэлийг тохох эсвэл аливаа

263 Гэр бүлийн гомеостазиs- гэр бүлийн эв нэгдэл

асуудлаар буруутгаж байдаг. Гэр бүл болгонд "золигт гарах хүн" байх бөгөөд гэр бүлийн гишүүн бүр ээлж дараалан энэ дүрд орох шаардлагатай гэж Р.Спек үздэг. Нэг гишүүн энэхүү дүрд удаан хугацаагаар байвал гэр бүл хямралд орно. Тиймээс "золигт гарах хүн"-ий дотоод чадавхийг дээшлүүлэх, өөрийн эрх, эрх чөлөөний төлөө тэмцэж энэ дүрээ гэр бүлийн бусад гишүүнд шилжүүлэх ёстой хэмээдэг.

Тухайлсан үйлчлүүлэгч болон "золигт гарах хүн"-ий эсрэг ойлголт бол гэр бүлийн эрүүл саруул гишүүн юм. Энэ хүн нь гэр бүлийн асуудалд бодитой хандаж дүгнэлт хийдэг учир нийгмийн ажилтанд тусалж чадах гишүүн юм.

Нийгмийн ажилтан гэр бүл дэх бодит үйлчлүүлэгчийг тогтоох шаардлагатай байдаг. Бодит үйлчлүүлэгч нь гэр бүлийн сөрөг харилцааны үр дүнд хамгийн их зовж шаналан хохирч байгаа гишүүн юм. Нийгмийн ажилтан бодит үйлчлүүлэгчийг хэд хэдэн уулзалтын дараа тодруулан таних тохиолдол бий. Энд анхаарах хэдэн зүйл байдаг. Үүнд: Хэрэв нийгмийн ажилтанд хандах санаачлагыг хүүхдүүдийнхээ төлөө санаа зовсон ээж гаргавал тухайн гэр бүлийн бодит үйлчлүүлэгч нь эцэг болж байдаг. Эсвэл санаачлагыг ач зээгийнхээ төлөө санаа зовсон эмээ гаргавал бодит үйлчлүүлэгч нь ээж болох тохиолдол элбэг юм. Зарим тохиолдолд тухайлсан үйлчлүүлэгч нь бодит үйлчлүүлэгч байх явдал бий.

Гэр бүлийн сэтгэл засалд В.Сатир "гэр бүлийн шаналал" хэмээх ойлголтыг оруулж ирсэн. Нийгмийн ажилтанд хандаж буй гэр бүлийн асуудал нь тухайлбал, хүүхэд хичээлээ таслах, уур уцаартай болох зэрэг нь хүүхдийн асуудал бус харин гэр бүлийн шаналал болж байдаг. Тиймээс нийгмийн ажилтан гэр бүлтэй анх уулзахдаа асуудлын шалтгааныг тодорхой шалгаалгүйгээр хүн болгонд хандаж "Таны бодлоор танай гэр бүл юунаас болж шаналж байна вэ?" хэмээн асууснаар анхнаасаа гэр бүлийн гишүүн бүр адил тэгш хариуцлага хүлээх учиртайг ойлгуулна хэмээн В.Сатир үзжээ.

Гэр бүлийн хамтын сэтгэл заслын зарчим

Гэр бүлийн хамтын сэтгэл заслын үндсэн зарчмуудыг анх Ж.Белл дэвшүүлсэн бөгөөд хожим зарим судлаачид түүнийг баяжуулсан юм.

Нэгдэх зарчим

Нийгмийн ажилтан анхнаасаа гэр бүлд бүхэлд нь анхаарлаа хандуулах шаардлагатай. Гэр бүлийн бүтэц, бүрэлдэхүүнтэй танилцаж сэтгэл заслын үйлчилгээг гэр бүлийн бүх гишүүдэд нэгэн зэрэг үзүүлэхээ ойлгуулна. Гэр бүлийн удам гарлын буюу түүхэн асуудлыг үл хөндөн "одоо, энд" гэсэн зарчмаар ажиллахыг Ж.Белл дэвшүүлсэн бол Ж.Бинг-Холл, В.Сатир нар гэр бүлийн удам гарлын түүхэн шинжилгээг шаардлагатай үед хийж болохыг санал болгожээ.

Хоёрдах зарчим

Сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх явцад гэр бүлийн зарим гишүүд нийгмийн ажилтнаас бусдынхаа харилцааг тасалж өөрөө тусдаа харилцаа тогтоохыг оролддог. Тухайлбал, утсаар ярих, уулзалтын цагаас өмнө ирэх, асуудлаа зөвхөн нийгмийн ажилтантай ярилцахыг тулгах гэх мэт. Тиймээс гэр бүлийн гишүүдээс гарч буй ийм саналыг хүлээж авахгүй байх нь зүйтэй. Хэрэв ганцаарчлан уулзахыг тулган шаардаад байвал өөр нийгмийн ажилтныг санал болгох хэрэгтэй болдог ч зарим тохиолдолд уян хатан хандах шаардлага тулгарна. Жишээ нь: эцэг эх нь хүүхдүүдийнхээ дэргэд бэлгийн амьдралынхаа асуудлыг дэлгэхийг хүсдэггүй учир энэ талаар нарийн яриа дэлгэхгүй байх нь зөв. Гэр бүлийн хамтын сэтгэл заслын үед гэр бүлийн гишүүд нэг нэгээсээ юу ч нуулгүй ярих ёстой юм.

Гуравдах зарчим

Гэр бүл дэх аливаа зөрчил нь хэн нэгний буруу биш харин гэр бүлийн дотоод харилцааны үр дүн юм. Гэр бүлийн аль нэг гишүүн бурууг өөртөө хүлээх явдал байдаг ч гэр бүлийн сэтгэл заслын үйл ажиллагаанд өөрийгөө буруутгах асуудлыг гаргаж болохгүй. Буруутгах нь өөрийгөө танин мэдэх болон өөрчлөх үйл явцад саад хийж үр дүнтэй үйл ажиллагааг үгүйсгэдэг.

Тиймээс гэр бүлд тулгарсан аливаа асуудал нь тодорхой нэг гишүүний буруутай үйл ажиллагаа бус гэр бүлд тогтсон буруу харилцааны үр дүн гэдгийг нийгмийн ажилтан ойлгуулах хэрэгтэй юм.

Дөрөв дэх зарчим

Гэр бүлийн аливаа асуудал эсрэг болон сөрөг шалтгааныг агуулдгийг нийгмийн ажилтан санаж байх ёстой. Үзэгдэл, үйл явдал бүр ямар нэг зүйлийн дохио сануулга болж байдаг.

Гэр бүлийн хамтын сэтгэл заслын зорилго, зорилт

Гэр бүлийн хамтын сэтгэл заслын зорилго, зорилтын талаар судлаачид санал нийлдэг. Үүнд:

1. Гэр бүлийн гишүүдийн хүсэл зориг, мэдрэмж, үнэт зүйл, айдас түгшүүрийн тухай сэтгэгдлээ шууд илэрхийлэхийг нэмэгдүүлэх, өөрөөр хэлбэл гэр бүлийн дотоод харилцааг илүү нээлттэй болгох.
2. Гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцааны шинэ арга хэлбэрийг бэхжүүлэх, өөрийн зан үйлээ хянах, харилцаа холбооны янз бүрийн хэлбэрийг чөлөөтэй сонгох боломжтой болгох.
3. Гэр бүл дэх тогтсон үзэл хандлагыг нураах, нийгмийн ажилтан дээр анх ирж буй гэр бүлийнхний хэрхэн харилцаж, ямар зан үйл гаргаж буйг тэдгээрийн суусан суудлын байрлалаар мэдэж болно. Тухайн гэр бүлд тогтсон уур амьсгалыг эвдэхийн тулд янз бүрийн арга хэрэгслийг ашигладаг. Тухайлбал, Р.Спек английн хэт ёсорхуу гэр бүлд зөвлөгөө өгөх үед шалан дээр хэвтэн тамхи татгал бүгдийн гайхшралыг төрүүлж нөхцөл байдлыг өөрчилж чаджээ. Мөн мэдрэлийн согогтой хүүтэй харьцахдаа яг түүнтэй адил зан үйл гаргаж байв. Үүгээрээ Р.Спек тогтсон байдлыг эвдэхийг оролдож байв. Гэр бүлийн сэтгэл заслын үйл ажиллагааг эхлэхдээ гэр бүлийн гишүүдийн тооноос нэгээр илүү сандал тавьсан тохилог өрөөнд явуулна. Эдгээр сандал дээр хэн хаана, хэний дэргэд сууж буйгаас гэр бүлийн бүтэц, харилцааг мэдэж болно. Сул сандлыг ашиглаж гэр бүлийн гишүүдийн суудлыг өөрчлөн, заримдаа нийгмийн ажилтан өөрөө энэ суудалд байраа эзлэн янз бүрийн хувилбараар уулзалтын шинжийг өөрчлөхийг эрмэлзэнэ.
4. Гэр бүлийн хамтын сэтгэл заслын үйлчилгээнд хамрагдаж буй гэр бүлийн гишүүд гомеостазисийг хангахын тулд шинэ үүрэг хариуцлагаа ухамсарлаж цаашдаа хадгалж болохоос гадна түүнээс татгалзаж болно. Нийгмийн ажилтан гэр бүлийн харилцааг тайлбарлан зохицуулагч болохоос бус үзэл бодлоо тулган шаардагч биш хэмээн Ж.Белл үздэг бол А.Ферейра, Ж.Бинг-Холл нар гэр бүлийн хуучин үүрэг хариуцлагыг устгаж шинэ үүрэг хариуцлагыг боловсруулах ёстой хэмээн түүнтэй санал зөрөлддөг юм.
5. Гэр бүлийн гишүүд эв нэгдэлтэй байх, харилцан хамааралтайгаа ойлгож байх.
6. Гэр бүлийн гишүүд өөртөө хуримтлуулсан бүхий л санаа бодлоо илэрхийлэх боломжийг олгох. Нэг нэгнийхээ талаархи сөрөг үзэл бодол, мэдрэмж, гоморхол, гансралыг илэрхийлэхгүйгээр жинхэнэ харилцаа холбооны тухай ярьж болдоггүй.

Зөвхөн сайн сайхан харилцаагаа ярьж зөрчилт асуудлаа нууцлаад байвал гэр бүл дэх түгшүүр нэмэгдэж, далд цухал, уур уцаарыг ихэсгэдэг байна. Дээрхи зорилго, зорилтуудаас харахад гэр бүлийн засал нь хүний оюун санааны гүнд ордоггүй харин зөвхөн харилцаан дээр тулгуурлаж явагддаг байна. Гэр бүлийн хамтын сэтгэл заслын үйлчилгээ нь 10-20 удаагийн уулзалтаас хэтэрч болохгүй юм. Энэ хугацаанд үр дүн гарахгүй бол ганцаарчилсан эсвэл зөвхөн гэр бүлийн хосуудад зориулсан сэтгэл заслын үйлчилгээг үзүүлэх хэрэгтэй болно. Ихэнхдээ уулзалтыг долоо хоногт нэг удаа 1,5-2 цаг хийвэл зохистой байдаг.

Гэхдээ уулзалтын үргэлжлэх хугацааны тухай судлаачид янз бүрийн үзэл бодолтой байдаг. Уулзалтын үед юу хийж амжуулахаас үл хамааран яг цагтаа дуусгах ёстой хэмээн Ж.Белл үздэг бол цаг хугацаанаас үл хамааран гэр бүлийн гишүүд дараагийн уулзалтаас илүү ихийг хүсэн хүлээх сэтгэл санааны өөдрөг итгэл найдвар төрсөн үед дуусгаж болно хэмээн В.Сатир үздэг.

Гэр бүлийн хамтын сэтгэл заслын үе шат

Гэр бүлийн хамтын сэтгэл заслын үйлчилгээг үзүүлэх Ж.Беллийн тодорхойлсон хэд хэдэн үе шатыг авч үзье. Анхны уулзалтаар гэр бүлийн гишүүдтэй танилцаж, нийгмийн ажилтантай тусдаа

харилцаа тогтоохыг урьдчилан сэргийлэхэд анхаарна. Анхны уулзалт нь агуулгын хувьд тийм ч баялаг биш юм. Хоёрдох уулзалтыг үр хүүхдүүдийг оролцуулахгүйгээр зөвхөн эцэг эхтэй хийнэ. Анхны болон хоёрдох уулзалтыг баримжаагаа олох үе шат хэмээн Ж.Белл нэрлэв. Хоёрдох уулзалтын үед гэр бүлийн асуудлыг яриулж, зохион байгуулалтын зүйлээ хэлэлцэн тохирч мэдээлэл цуглуулахын зэрэгцээ гэр бүлийн хамтын сэтгэл заслын зарим хандлага зарчмыг эцэг эхэд тайлбарлана. Гэр бүлийн хамтын сэтгэл заслын үйл ажиллагаанд ихэнхдээ дан гэр бүлийг (эцэг, эх, үр хүүхдүүд) хамруулдаг ч холимог гэр бүлийг (эцэг эх, эмээ өвөө, үр хүүхэд, төрөл садан) заримдаа татан оролцуулах явдал бий.

Эцэг эхтэй уулзах анхны уулзалтаар эцэг эхийн ярьсан зүйлийг хожим хүүхдүүдийнхээ дэргэд ярьж буйтай харьцуулах боломжтой болно. Энд хэн хэний төлөө санаа тавин ярьж байгааг, гэр бүлийн дүрэм журам, төлөвлөгөөг хэн тодорхойлдог эсэх, хэн хэнийг удирдаж буйг, хэн бага эсвэл их ярьж байгааг, ямар өнгө аясаар ярьж буйг, юуг нууж байгааг, гэр бүлийн гишүүд хямралд хэрхэн хандаж буйг, асуудал үүсэх нуугдмал сэдэл, асуудлыг хэнтэй холбож байгааг, асуудал ямар нөхцөл байдлыг үүсгэж байгаа зэргийг анхааран сонсож ажиглах ёстой. Анхны уулзалтын дараа нийгмийн ажилтанд тухайн гэр бүлийн талаар төсөөлөлтэй болж улмаар цаашдаа нэмэгдэж засварлагдаж байдаг.

Нийгмийн ажилтан эцэг эхэд үйл ажиллагааны зорилго, зорилтыг нарийн тайлбарлаж өгнө. Үүнийг Ж.Беллийн ярьснаар харж болно. “Би гэр бүлийн ганц эсвэл бүх гишүүд нь гэр бүлийн харилцаандаа сэтгэл дундуур байдаг олон гэр бүлүүдтэй ажиллаж байв. Тэдэнтэй уулзаж байхад эцэг эх нь үр хүүхдүүдтэйгээ илэн далангүй ярилцаж чаддаггүйгээс үл ойлголцол үүсч хүүхдүүд нь тийм ч аз жаргалтай байдаггүй байв. Эдгээр гэр бүлтэй ажиллахад хүүхдүүдийн байдалд өөрчлөлт оруулахад анхаарах хэрэгтэй байдаг. Би та бүхэнд хэрхэн хамтдаа ажиллах талаар ярья. Дараагийн уулзалтанд та нар хүүхдүүдтэйгээ хамт ирээрэй. Хүүхдүүд гэр бүлийн асуудлыг хэрхэн ойлгож буйг яриулах боломжийг олгоё. Тэд гэр бүлийн гишүүд учир чөлөөтэй байж гэр бүлд таалагдахгүй байгаа зүйлээ ярина. Бусад гэр бүлийн хүүхдүүдийн ярьснаас харахад гэр бүлд тогтоосон дүрэм, хязгаарлалтанд гомдоллож байдаг. Энэ бол хүүхдүүд хэр чөлөөтэй байгааг болон илэн далангүй нээлттэй байгааг мэдэж болох арга юм. Хүүхдүүдийн өгүүлж буйг эцэг эх үнэн сэтгэлээсээ хүлээж авах нь чухал. Дараа дараагийн уулзалтуудад тэдний сэтгэлийг зовоож буй зүйлийг яриулахын зэрэгцээ гэр бүлийн асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах эрхтэйг нь ойлгуулах хэрэгтэй байна. Эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ үйлдлийн учир шалтгааныг мэдэж тэднийг үнэн сэтгэлээсээ сонсож сурах нь ач холбогдолтой.

Сэтгэл заслын үйл ажиллагаа хир удаан үргэлжлэхийг би хэлж мэдэхгүй. Гэхдээ би та бүхэнтэй хамт байх боловч өмнөөс чинь шийдвэр гаргахгүй. Гэр бүл чинь танайх учраас шийдвэр чинь бас танайх байх ёстой. Би хүүхдүүдийн үүсгэж буй асуудлын тухай ярихын оронд яагаад тэд ийм үйлдэл гаргаж буйг ойлгож хэлэлцэх болно. Хүүхдүүдийн ярьсан зарим зүйл та нарт цоо шинэ байдаг бол зарим зүйл ойлгомжтой мэт санагдана. Хүүхдүүд эцэг эхээ муулах үед танд маш хүнд байх бөгөөд үүнийг даван туулах ёстой. Хүүхдүүдийг ойлгох нь сэтгэл заслын үйл ажиллагааны чухал хэсэг юм²⁶⁴

Харин В.Сатир уулзалтын үед нилээд уян хатан ханддаг бөгөөд эцэг эхийг буруугүй гэдгийг ойлгуулна. “Та нарын хийсэн болгон чинь сайн сайхны төлөө байдаг. Гэхдээ санаснаар болоогүйд сэтгэлээр унасан байх л даа. Бид бүгд л хүн юм чинь хийсэн болгон маань амжилтанд хүрдэггүйг ойлгох хэрэгтэй. Та нар чадах бүхнээ хийжээ. Гэр бүл нь тодорхой хэм хэмжээгээр зохицуулагдаж байдаг бөгөөд танай гэр бүл ч мөн дүрмээр зохицуулагдаж байгааг та нарт мэдүүлэхийг би хүсч байна. Гэр бүлийн гишүүн ямар нэгэн зүйлд шаналж байвал бусад нь туслахыг оролддог. Та нар өөр өөрсдийн хязгаарлагдмал хүрээндээ тулгуурлаж байдаг учир гэр бүлд болж буй явдлыг бүхэлд нь харж чадахгүй байна. Харин бүгд хамтдаа сууж асуудлаа ярьж дүгнэснээр асуудлыг шийдвэрлэхэд үнэлж баршгүй хувь нэмэр оруулна.”²⁶⁵ Эцэг эхтэй уулзан цаашдын ажлаа сэтгэлзүйн хувьд

264 Bell J. Family group therapy. Washington. 1961, p 22

265 Satir V. Conjoint therapy theory: Condor book. Paloalto 1967, p 117.

бэлдсэний дараа хүүхдийг оролцуулна. Гэр бүлийн хамтын сэтгэл засалд гэр бүлийн бүх гишүүд болон нийгмийн ажилтан оролцоно. Хэрэв гэр бүлийн нэг л гишүүн ирээгүй бол нийгмийн ажилтан уулзалтыг хойшлуулна.

Нийгмийн ажилтан ямагт хөндлөнгийн ажиглагчийн байр суурийг эзлэх ёстой. Гэр бүлтэй ажиллаж байгаа нийгмийн ажилтан өөрийн эрхгүй тухайн гэр бүлийн гишүүн болж татагдаад орчихдог. Өөрөөр хэлбэл, гэр бүлийн гишүүний ямар нэгэн үүргийг нийгмийн ажилтанд тохчихдог юм. Тиймээс үүнээс урьдчилан сэргийлэхийн тулд гэр бүлтэй ажиллаж буй нийгмийн ажилтан хосоороо эсвэл багаар ажилладаг.

Нийгмийн ажилтан хамтрагчтай ажилласнаар гэр бүлээс ирж буй их хэмжээний мэдээллийг цэгцэлж хэлэлцэх боломжтой болно. Учир нь ганц хүн үүнийг хийхэд бэрх байдаг. Сэтгэл заслын үйлчилгээ өндөр хөгжсөн орнуудад эсрэг талаасаа нэвт харагдах тольтой тусгай өрөөнд гэр бүлтэй уулздаг юм. Тусгай өрөөний толин хананы цаанаас нийгмийн ажилтны баг гэр бүлийг анхааралтай ажиглаж байдаг. Багаар ажиллахыг Ж.Бинг-Холл чухалчлан үзсэн байдаг. Хамтрагч нь ажлын дараа үзэл бодлоо илэрхийлэх эсвэл үйл явцад шууд оролцож болно. Тэрбээр нийгмийн ажилтанд утасдаж заавар өгөх эсвэл шууд өрөөнд орж хүмүүстэй танилцаад асуух зүйл байгаагаа илэрхийлж болно. Мэдээж анхнаасаа гэр бүл нь хамтрагчийн талаар мэдээлэл авсан байх ёстой.

Нийгмийн ажилтан уулзалтын үед завсарлага авч багтайгаа зөвлөлдөж болох бөгөөд шаардлагагүй яриаг таслах зорилготой ч байж болно. Үүнээс гадна нийгмийн ажилтан нь гэр бүлийн гишүүдийн жигд оролцоог хангах хэрэгтэйг Ж.Белл анхааруулжээ. Өөрөөр хэлбэл, нэг нь их ярьж бусдын анхаарлыг өөртөө төвлөрүүлэх бус харин бүгд адил тэгш эрхтэй ярилцлагад оролцох ёстой.

Гэхдээ энэ талаар судлаачид янз бүрийн саналтай байдаг. Хэрэв гэр бүлийн нэг гишүүнтэй хийх ярилцлага удааширвал бусад нь сонсож биеэ барьж түгшүүртэй байдалд орно. Нэгтэй нь ярьж байх явцад бусад нь 10-20 минут түгшүүртэй байдалтай байхыг ач холбогдолтой хэмээх үзэх нь зарим гишүүд биеэ барьж чадахаа больж, үг хэлүүлэхийг шаардсанаар өнгөц санал солилцоог тасалдаг. Тиймээс энэ нь жигд оролцоотой ярилцлагаас илүү үр дүнтэй байж болох юм.

Ж.Беллийн дэвшүүлсэн гэр бүлийн сэтгэл заслын нэг дэх үе нь гэр бүлийн гишүүд бүрэн бүрэлдэхүүнээрээ нийгмийн ажилтан дээр ирснээр эхэлнэ. Энэ үеийг “хүүхэд төвт харилцаа” гэх бөгөөд бүх анхаарлаа хүүхэдтэй харилцах асуудал дээр төвлөрүүлж түүнийг өөртөө итгүүлэн хамгаалж чадна гэдгийг мэдрүүлнэ. Энэ шатанд хүүхдийг гэр бүлийн сэтгэл заслын үйл ажиллагаанд бэлдэх үе байдаг. Дараагийн үеийг “эцэг эх, үр хүүхдүүдийн харилцаа”-ны үе шат хэмээх бөгөөд эцэг эх нь үр хүүхдийнхээ дутагдлыг болон сэтгэл зовоож буй асуудлаа ярьна. Эцэг эхийнхээ яриаг уур уцаар, эсэргүүцэлгүй сонсохын тулд хүүхэд хамгаалагчтай гэдгээ мэдэрч байх ёстой. Эцэг эх нь гэр бүлээ аз жаргалтай болгохын тулд нийгмийн ажилтанд хандаж бүгдээрээ хамтдаа цугларч тусламж авах зорилготой гэдгээ илэрхийлвэл чухал юм. Ихэнх хүүхдүүд гэр бүлдээ үзэл бодлоо илэрхийлэх боломжоор хомс байдаг. Тиймээс бүгд биеэ барилгүй гэр бүлийн асуудлаа ярихыг нийгмийн ажилтан хүснэ. Хүүхдийн ярьсныг эцэг эх анхааралтай сонсож, юу ч ярьсан шийтгэж зодохгүй гэдэг ам өчгийг эцэг эхээс авна.

Ер нь хүүхдүүд түрүүлж ярьдаггүй, бага насны хүүхэд үргэлж эцэг эхийнхээ талд байдаг учир гадны хүний дэргэд юу ч ярихыг хүсдэггүй. Өсвөр насны хүүхдүүд ярьдаг ч үзэл санаагаа тодорхой бус илэрхийлдэг. Хэрэв хүүхэд ярихгүй зөрүүдлээд байвал гэр бүлийн өөр нэг гишүүнийг ярихыг хүснэ. Түүнийг ярьж байх үед “Тэр зөв ярьж байна уу? үгүй юу?” хэмээн хүүхэд хандаж асууна. Хүүхэд энэ асуултанд зөв эсвэл үгүй хэмээн ямар нэг хариултыг заавал өгдөг. Ийнхүү хүүхдийг ярианд өдөөж оруулах хэрэгтэй юм.

Ж.Бинг-Холл үзэхдээ уулзалтыг тухайн үед хамгийн бүтэлгүй азгүй байгаа гишүүнээс эхлэхийг зүйтэй гэнэ. Гэр бүлийн гишүүд хаана, хэрхэн суудлаа эзэлснийг анхаарч бусдаасаа тусдаа суусан нэгэн гишүүнд хандан гэр бүлийн гишүүдийг танилцуулахыг хүснэ.

Хүүхэд ярьж эхэлсний дараа тодорхой асуудал руу түүний яриаг чиглүүлнэ. Гэр бүлийн хамтын сэтгэл заслын нэг дэх үед эцэг эхийн биелүүлж чадах хүүхдээс тавьсан зарим шаардлагыг биелүүлэх боломжийг олж чадвал үр дүнтэй юм. Учир нь дараагийн уулзалтанд хүүхэд ямар нэг өөрчлөлт гарна гэдэгт урамшин ирдэг. Гэхдээ эцэг эх хэлсэндээ тэр бүр хүрэхгүй тохиолдол их

байдгаас нийгмийн ажилтан тэдэнд үр дүнтэй ажиллахын тулд бүгд хувь нэмрээ оруулахыг хүсч ухуулна. Эцэг эхийн үйлдлийн сөрөг үр дагаварыг тайлбарлан эцсийн дүндээ уулзалт тасарч, зогсож болохыг сануулна. Хэрэв эцэг эх ямар нэг өөрчлөлтийг эсэргүүцвэл анхны уулзалтыг сануулах хэрэгтэй болно. Нийгмийн ажилтнаас санал болгож буй буултыг эцэг эх өөр өөрөөр ойлгож болзошгүй юм. Эцэг эх хоёрын хооронд зөрчил үүсэж эх нь хүүхдийн хүссэн зүйлийг авч өгөхийг зөвшөөрч эцэг нь үгүйсгэх зэргээр хүүхдийг улам эмзэглүүлж зожиг болгоно.

Нэг дэх үед эцэг эх яриагаараа манлайлан давамгайлах явдлыг гаргахгүй байхыг анхаарах ёстой. Энэ нь хүүхдийг улам дарамтанд оруулж байдаг юм. Эцэг эх энэхүү шаардлагыг хүлээж авахгүйгээр яриагаа үргэлжлүүлээд байвал нийгмийн ажилтан үл тоосон байдал үзүүлэх, хүүхэд рүү анхаарлаа хандуулж түүний дэргэд очих гэх мэт хязгаар тавьж болно. Хүүхдийн ярианд эцэг эх нэмэлт хийж болох бөгөөд буруутгах хандлагатай байвал хүүхдийн үзэл санаатай тулгаж үзэх хэрэгтэй. Нэг дэх үеийн төгсгөлийг хүүхдүүд тодорхойлно. Хүүхдүүд эцэг эхдээ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлдэг болсноор энэ үе дуусгавар болно.

Хоёр дах үеийг "эцэг эх, үр хүүхдийн харилцаа" гэх бөгөөд эцэг эх нь хүүхдүүдээ муулах, буруушаах, гомдох зэргээр цочроо ихтэй байдаг. Нэр бүлийн гишүүн бүр хэлэх зүйлээ ил гаргах боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ ярих бололцоогүй нэгнийг нийгмийн ажилтан дэмжих ёстой. Нийгмийн ажилтан яригдаж буй эсрэг, сөрөг асуудлыг бүгдэд дүгнэн ярьж байснаар гэр бүлийн гишүүд нэгдмэл ойлголт авахад тустай. Сэтгэл заслын үйл ажиллагаанд оролцож буй бүх хүмүүс хүүхдэд ойлгомжтой энгийн хэллэгээр ярьснаар харилцан ойлголцох үйл явцад эерэг нөлөө үзүүлнэ.

Гэр бүлийн сэтгэл засалд хэрэглэдэг техникийн нэгэн арга барил бол зүйрлэл харьцуулалтыг ашиглах явдал юм. Янз бүрийн үлгэр, өгүүлэл, дүрийг сэтгэн зохиож ажилдаа хэрэглэхийн сацуу санаагаа илэрхийлж чадахгүй байгаа хүүхэдтэй зураг зуран ярилцаж болдог. Үүнээс гадна гэр бүлийн гишүүдийг өөрсдийнхөө тухай, санаа зовоож буй зүйлийнхээ талаар болон гэр бүлээ бүхэлд нь хамарсан үлгэр, түүх, өгүүллийг зохиохыг хүсч болно. Энэ үе шатны гол үр дүнг гэр бүлийн гишүүдийн сэтгэлдээ хуримтлагдсан сөрөг сэтгэлийн хөөрлөө ил гаргаснаар дүгнэж болно. Ийнхүү сөрөг сэтгэлийн хөөрлөө харилцан устгаснаар дэмжлэг туслалцаа, тэгш эрхт байдал, хайраа хадгалан үлдэх чадварыг олж авна.

Гэр бүлийн хамтын сэтгэл заслын үйлчилгээний үед гарах харилцан шүүмжлэлүүдээс нийгмийн ажилтан хамгийн эерэг талыг олж анхаарлаа хандуулах шаардлагатай байдаг. Гэр бүлийн гишүүдийн харилцааны сувгуудыг цэвэрлэсний дараа гуравдахь шат буюу эцэг эх хоёрын хоорондын харилцааны асуудлаа шийдвэрлэх үе эхэлдэг. Эцэг эх, үр хүүхдүүд бүгд сөрөг сэтгэлийн хөөрлөө бүрэн гүйцэд гаргаагүй байхад эцэг эх хоорондоо маргалдаад эхэлбэл бүгдийг хамарсан зөрчил хэрүүл үүснэ. Тиймээс нийгмийн ажилтан нөхцөл байдлыг байнга хяналтандаа байлгаж гэр бүлийн бүх гишүүдийн сөрөг сэтгэлийн хөөрлийг бүрэн гаргуулж байж дараагийн хэлэлцэх асуудал руу орно.

Гуравдахь үе шатыг "эцэг эхийн харилцаа" гэх ба гэр бүлийн хамтын сэтгэл заслын шийдвэрлэх үед тооцогдоно. Ж.Белл гэр бүлийг энэ үе шат руу аядуухан хөтлөхдөө эцэг эхийн хүсэлтийг харгалздаг. Тэдний эрэлт хүсэлт нь хүүхэддээ гомдоллох явдал бөгөөд хүүхдийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдэнэ. Энэ тухай яриа аажмаар эцэг эхийн хоорондын харилцааны асуудал руу шилжинэ. Ер нь хүүхдийн зан үйлийн гажуудлын үндэс нь эцэг эхийн харилцааны мөн чанарт оршино.

Хүүхдийн асуудал үүсэхэд эцэг эхийн харилцаанд хэрхэн нөлөөлдөг вэ? Энд хэд хэдэн тайлбар байдаг. Гэр бүлийн домгийг эцэг эх хоёр бий болгож, төрүүлсэн хүүхэд нь энэхүү домогт өөрийн эрхгүй татагдан орно хэмээн Ж.Бинг-Холл үздэг.

Гэр бүлийн хосуудын санааг зовоож буй асуудлыг шахан зайлуулах үүднээс харилцан тохиролцсон хамгаалалтыг үүсгэдэг нь гэр бүлийн домог юм. Анхандаа сэтгэл зовоосон асуудлаа хосууд гэрлээгүй байхдаа тус тусдаа даван туулах оролдлого хийдэг бол амьдралаа холбосноор ханийнхаа дэмжлэгийг авна.

Гэр бүлийн домог дээр тулгуурласан гэрлэлтийн хоёр хэв маяг байдаг. *Сэтгэл зүйн хамгаалалтаараа төсөөтэй хүмүүсийн гэрлэлт нь нэг дэх хэв маягийг* үүсгэнэ. Өөрт байгаа адил

төсөөтэй дутагдлаа хамтран шахан үгүйсгэхдээ хамгаалалтаа бэхжүүлнэ. Тухайлбал, гэр бүлийн хос бэлгийн харилцааны асуудалтай байг. Тэдний гэр бүлийн домог "Бид нэг нэгийгээ олсондоо аз жаргалтай байна. Аз жаргалтай гэр бүлийн үндэс нь бэлгийн харилцаа биш. Бэлгийн харилцааны асуудал бидний сэтгэлийг огт зовоодоггүй. Бид нэг нэгийгээ ойлгодог, нөхөрлөдөг, тусалдаг" гэж илэрхийлэгдэнэ.

Гэрлэхээс өмнө хосууд тус тусдаа бэлгийн харилцааны асуудалтай байсан бөгөөд гэрлэсний дараа энэ нь гэр бүлийн домог болтлоо хэлбэрждэг. Төрүүлсэн хүүхэд домгийг хамгаалахыг оролдоно. Хүүхэд эцэг эхийнхээ хүсэн хүлээсэн итгэлийг даахгүй бол бүх бурууг түүнд тохож "золигт гарах хүн" болгодог. Хэрэв хүүхэд эцэг эхийн талд орвол гэр бүлийн домог амь бөхтэй оршино.

Эсрэг тэсрэг сэтгэлзүйн онцлогтой хосууд гэрлэснээр гэрлэлтийн хоёр дах хэв маягийг бүрдүүлнэ. Эд нар "Өөрийнхөө үгүйсгэсэн дутагдлыг нөгөөдөө дамжуулдаг бол ханийнхаа үгүйсгэсэн зүйлийг хүлээж авснаар нэг нэгийгээ нөхөж байдаг" хэмээн үзэгсэд юм. Тэд нэг нэгийгээ туйлын сайнд тооцох ба гэрлэлт нь хүчтэй хайр дурлал дээр тулгуурлана. Анхандаа бүх зүйл сайн сайхан байж, улмаар цаг хугацаа өнгөрснөөр нэгийгээ туйлчлах үзлийн оронд эсэргүйцэл, дургүйцэл ирнэ. Ийнхүү гэрлэлт дараагийн шатанд орсноор байнгын хэрүүл маргаан, зөрчил тэмцэл архаг шинжтэй болж, гэр бүл ихэнхдээ салалтаар дуусна. Ийм гэр бүлд төрсөн хүүхэд эцэг эхийнхээ аль нэгний адислалын объект болдог. Эхийгээ дуурайвал эцэг нь загнах эсвэл эцгийн талд орвол эх нь уурлах зэргээр хүүхэддээ бүх бурууг тохож байдаг.

Эцэг эх, үр хүүхдийн бүхий л сөрөг сэтгэлийн хөөрөл гарч дууссаны дараа гуравдах үе шат эхэлдэг бөгөөд хүүхдүүд ерөнхийдөө гэр бүл дэх харилцаанд сэтгэл ханамжтай болдог. Эцэг эхийн харилцааг шийдвэрлэх асуудал ихэнхдээ 6 дах уулзалтын үед болдог.

Гуравдах үе шат эхлэхийн өмнө нийгмийн ажилтан ямар нэгэн тайлбар хийхээс зайлсхийхийн хамт янз бүрийн аргаар яриаг өрнүүлж байдаг. Эцэг эхийн яриа улам илэн далангүй болж өөртөө дүн шинжилгээ хийх аястай болж ирдэг. Энэ тохиолдолд нийгмийн ажилтан болж буй байдалд тайлбар хийж болно. Гэр бүлийн хамтын сэтгэл заслын үйлчилгээнд ашигладаг 4 төрлийн тайлбарыг Ж.Белл тодорхойлсон байдаг.

1. *Эргэцүүлсэн дүгнэх тайлбар.* Гэр бүлийн гишүүдийн хооронд хангалттай дотно харилцаа байхгүй болон илэн далангүй нээлттэй, харилцан дэмжлэг дутмаг байгаа үед энэ тайлбарыг хийх нь ач холбогдолгүй. Харин гэр бүлийн гишүүд ойр дотно болсон үед энэ тайлбарыг хийхэд үр дүнтэй юм.
2. *Холбох тайлбар.* Энэхүү тайлбар нь гэр бүл дэх үйл явдал, сэтгэл санаа, үүрэг хариуцлага, мэдрэмж, сэтгэлийн шаналалын мөн чанарыг холбоход тусална. Гэр бүлийн гишүүд нэг нэгийгээ ойлгон хүлээж авах хөрс суурь бэлтгэгдсэн тохиолдолд холбох тайлбар хийнэ. Ийм тайлбарыг В.Сатир өргөн ашигладаг. Холбох тайлбар нь гэр бүлийн хамтын сэтгэл засалд нэн чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд гэр бүл нь сэтгэл заслын үйлчилгээнд хамрагдсаныхаа дараа сэтгэл зовоож байгаа зүйлээрээ, мэдрэмжээ, үүргээрээ холбогдох чадвартай болсон байх ёстой хэмээн үздэг.
3. *Өөрчлөн шинэчлэх тайлбар.* Энэхүү тайлбар нь өнгөрсөн болон өнөөдрийн асуудлыг салгах зорилготой юм. Гэр бүлийн гишүүдийн сэтгэлийг өнөөдөр зовоож буй асуудал болон түүнийг нийгмийн ажилтанд ойлгуулахыг оролдож байгаа үед өөрчлөн шинэчлэх тайлбарыг хийнэ.
4. *Харьцуулах тайлбар.* Тухайн гэр бүлийг бусад гэр бүлүүдтэй харьцуулан дүгнэснээр гэр бүлийн гишүүдэд ойролцоо асуудалтай өөр гэр бүлүүд бас байдгийг ойлгуулан айдас түгшүүрээс салгахад туслана. Бусад гэр бүлийн асуудлыг ярьж тайлбар хийдэг.

Гэр бүлийн хосуудын яриа илэн далангүй, нээлттэй болохын хирээр тайлбарыг ихэсгэдэг. Гэр бүлийн хосууд нэг нэгэндээ буулт хийх, бие даасан байр суурийг хүлээн зөвшөөрөх, эв нэгдэлтэй байхын үнэ цэнийг мэдэрснээр эцэг эхийн харилцааны үе шат дуусгавар болно.

Үүний дараа "Хүүхдүүдийн харилцаа"-ны дөрөвдэх үе шат эхэлнэ. Хэрэв тухайн гэр бүл нэг хүүхэдтэй бол түүний асуудлыг бүх гишүүд хэлэлцдэг. Харин 2 ба түүнээс дээш тооны хүүхэдтэй гэр

бүлд хүүхдүүдийн харилцааны үе шат хоёр тохиолдолд үүснэ. Нэгдүгээрт, хүүхдүүдийн гомдол эцэг эхдээ чиглэсэн биш харин ах эгч дүү нар руугаа чиглэвэл; хоёрдугаарт, эцэг эх нь хүүхдүүдийнхээ хоорондын харилцаанд сэтгэл дундуур байгаагаар илэрхийлбэл хүүхдүүдийн харилцааны үе шат эхэлнэ. Энэ шатанд эцэг эх, үр хүүхдүүд ярианд жигд тэнцвэртэй оролцож, анхааралтай, тэвчээртэй сонсох чадвартай болсон байна. Энэ нь гэр бүлийн хамтын сэтгэл заслын үйлчилгээ төгсгөлийн шатанд орох дохио болно.

Сэтгэл заслын үйл ажиллагаа дуусгавар болох хэд хэдэн шинж чанар байдаг.

1. Гэр бүлийг зовоож байсан ихэнхи шаналалууд үгүй болсон байна. Гэхдээ зарим нь огт алга болоогүй ч хямраах шинжээ алдсан байдаг.
2. Уулзалтын үед гэр бүлийн гишүүд баяр баясгалантай инээд хөөртэй болсон байна. Эцэг эх нь алиалах, ёгтлох, хошигнох зэргээр эрүүл саруул уур амьсгалыг бий болгодог.
3. Нийгмийн ажилтан уулзалт болгоныхоо эхэнд долоо хоногийн турш гэр бүл хэрхэн амьдарч, ямар үйл явдал болсныг асуухад бүгд сайн сайхан зүйлийг ярьж эхэлнэ.
4. Гэр бүлийн гишүүд нэг нэгнийхээ бие даасан бүрэн эрхт байдлыг хүлээн зөвшөөрдөг. Хүүхдүүд санаачлагаараа гэрийн ажилд идэвхтэй оролцоно.
5. Гэр бүлийн гишүүд өөрсдөө бүх зүйл сайн сайхан бүтэмжтэй болж байгааг хэлэн дахин уулзах шаарлагагүйг илэрхийлнэ.

Гэхдээ сэтгэл заслын үйлчилгээ дуусгавар болж буйг ихэнхдээ нийгмийн ажилтан өөрөө зарладаг. Үүнийг 2 замаар хийж болно.

- I. Нийгмийн ажилтан тухайн гэр бүлд гарсан эерэг өөрчлөлтүүдийг сануулж, бие даах чадвартай болсныг дүгнэн ярина.
- II. Нийгмийн ажилтан тухайн гэр бүлийн цаашдын амьдралыг яриулж, гэр бүлийн гишүүд өөрсдөө асуудлаа шийдвэрлэх болсныг хэлнэ.

Гэр бүлийн хамтын сэтгэл засалд нийгмийн ажилтан ямар үүрэгтэй вэ?

- 1) Асуудлыг ярьж гэр бүлийн гишүүдийг бүх талаар дэмжих;
- 2) Сөрөг мэдрэмж, сэтгэлийн хөөрлийг шавхан гаргах;
- 3) Сэтгэл заслын үйл явцын динамикийг анхааралтай ажиглан залах;
- 4) Гэр бүлийн гишүүдийн хоорондын холбоо харилцааг дэмжихийн зэрэгцээ бие хүн болгоны өвөрмөц шинжийг хадгалан бие даасан байр суурийг төлөвшүүлэх.

Сэтгэл заслын үйл ажиллагааны үед юу болдог вэ? Гэр бүлийн гишүүд юу шинээр мэдэж авдаг вэ?

1. Тухайлсан үйлчлүүлэгчийн мөн чанар шалтгааныг мэдэх, энэ тухай бүгдийн саналыг сонсож эргүүлж бодох боломжийг олгох;
2. Гэр бүлийн асуудал, шаналал, зовлонг бүгд тэгш хуваалцах хариуцлагатай гэдгээ ойлгох,
3. Гэр бүл дэх амьдрал сайжран өөрчлөгдөхөд хүн бүр хувь нэмрээ оруулна гэдгийг ухамсарлах.
4. Гэр бүлийн дотоод уур амьсгалыг өөрчилж болно гэдэгт итгэх.

Гэр бүлийн хамтын сэтгэл заслын үйлчилгээний үр дүнд гэр бүлийн гишүүд нэг нэгнийхээ үнэ цэнийг мэдэрч, хамтдаа байхын ач холбогдлыг ойлгоно.

Гэр бүлийн хамтын сэтгэл заслын үйлчилгээг үзүүлэх арай өөр хандлага бий. Тухайлбал, зохион байгуулалтын асуудлаа хэлэлцсэн анхны хоёр уулзалтын дараа гэр бүлийн түүхэн он дарааллын судалгааг В.Сатир явуулдаг.

В.Сатир гуравдахь уулзалтандаа гэр бүлийн бүх гишүүдийг цуглуулан танилцахдаа эцэг эхийн анх яаж танилцсанаас эхлэн тэдний бага насыг сонирхон улмаар анхны хүүхдээ төрүүлсэн үеийг яриулна. Энэ үед хүүхдийг ярилцлаганд татан оруулна.

В.Сатирын сэтгэл заслын үйлчилгээ 3 үе шаттай үргэлжилнэ.

1. Хүүхэд төрөхөөс өмнөх хосуудын танилцсан болон гэр бүл болсон түүх

2. Хосуудын бага байх үеийг болон тэдний эцэг эхийн гэр бүлийн харилцааг мэдэхээс гадна өмнө нь гэр бүлтэй байсан эсэхийг сонирхоно.
3. Хүүхэд төрүүлсэн үеийн түүхийг мэднэ.

Эдгээр үеүдийн үйл явдлыг хожим тодорхой хэлэлцэж дуу хураагуур эсвэл цаасан дээр буулгадаг. Үүгээрээ В.Сатир дараах зорилтыг тавьж байна. Нэгдүгээрт, нийгмийн ажилтан анхнаасаа өөрийгөө хөндлөнгийн ажиглагчийн байр сууринд аваачна. Хоёрдугаарт, гэр бүлийн амьдралын тухай тодорхой мэдээлэл авна. Уулзалтанд ирсэн гэр бүлийн гишүүдээр хязгаарлагдахгүйгээр гэр бүлийн бүхий л нөхцөл байдлыг тодорхойлж байдаг өөр гишүүдийн тухай мэдээллийг авах шаардлагатай. Тухайлбал, эмээ өвөө эсвэл мэдрэлийн согогтой хүүхэд байж болох юм. Гуравдугаарт, энгийн асуултууд тавьснаар гэр бүлийн гишүүдийн түгшүүрийг арилгах, тайвшруулах зорилготой. Дөрөвдүгээрт, уулзалтаа шууд хосуудын харилцаанаас эхлэхгүйгээр хүүхэд төрөх хүртэлх хосуудын амьдралыг сонирхон хангалттай ярьна. Тавдугаарт, гэр бүлийн амьдралын түүхийг сонирхсоноор өөрсдийн амьдралд анализ хийж болно гэдгийг ойлгуулна.

Нийгмийн ажилтан нь ханиа хэрхэн сонгосон болох, амьдралын ямар төлөвлөгөө боловсруулж байсан, ер н хань, үр хүүхдээ ямар байгаасай гэж бодож байсан талаар сонирхдог.

Үүний дараа хосуудын эцэг эхийн тухай асуудалд анхаарлаа хандуулна. Хосуудын эцэг эхчүүд хэн, хаана амьдардаг, хүүхдүүдийнхээ тулгарч буй асуудал бэрхшээлд хэрхэн ханддагыг мэдэх хэрэгтэй. Ингээд түүхэн мэдээлэл цуглуулах ажилд хүүхдийг оролцуулах мөч ирнэ. Хүүхэд гэр бүлийн түүхийг сонсоод үлэмж их шинэ зүйл мэдэж авсан учир өөрийгөө гэр бүлд чухал үүрэг гүйцэтгэдэг болохоо мэдэрнэ. Мөн хүүхдийн бага насны дурсамж болгоныг мэдэх нь чухал ач холбогдолтой. Хүүхдийг ярьж байх үед бүхий л талаар дэмжин урамшуулж байх хэрэгтэй.

3-4 уулзалтанд гэр бүлийн түүхийг бичиж дуусна. Тухайн гэр бүлийн үе үеийнхний түүхэн нөхцөл байдал, асуудлыг мэдсэнээр өнөөдрийнхөө асуудалд орно. Эдгээр уулзалтууд нь сэтгэл заслын үйл явцыг зөөлрүүлж, гэр бүлийн гишүүдийг тайвшруулж өгдөг. Үүний бүхий л гишүүд нээлттэй, илэн далангүй болохын хэрээр гэр бүлийн түүхийн ач холбогдол багасч, сэтгэл заслын ажил "одоо, энд" гэсэн зарчмаар явагдах болно.

В.Сатирын сэтгэл заслын ажлын нэгэн онцлог зүйл бол гэр бүлийн гишүүдээс мэдрэмжийг нь асуух явдал юм. Тухайлбал, танай ээж энэ тухай ярьж байхад та юу мэдрэв? гэх мэт.

В.Сатир нь Ж.Беллийг бодвол гэр бүлийн гишүүдийн ярих хугацаанд хязгаар тавин жигд оролцуулж тэнцвэрийг хангахыг чухалчилдаггүй. Мөн тэрбээр "гэр бүлийн уран баримлын" аргыг хэрэглэж байв. Нийгмийн ажилтны удирдлаган доор гэр бүлийн гишүүд өөрсдийн төрх байрлалаар гэр бүлийн дотоод харилцааг дүрслэхийг оролдоно. "Уран баримлууд" нь гэр бүлийн тулгамдсан асуудлаас гадна гэр бүлийн түүхэн үйл явдал, эрч хүч, нөөцийг агуулна. Нийгмийн ажилтан "уран баримал" барих үйл явцад идэвхтэй оролцон гэр бүлийн гишүүдэд янз бүрийн даалгавар өгнө. Тухайлбал, эхнэр эсвэл нөхөртэйгөө ямар харилцаатай байхыг хүсдэгээ дүрсээр үзүүлэх, хүүхдүүд ямар байвал баярлахыг харуулах гэх мэт. "Уран баримал" зохиомж нь гэр бүлийн харилцааг тодорхой үзүүлдэг учир гэр бүлийн гишүүдэд ихийг бодогдуулна. Гэр бүлд тогтсон хуучин хандлага үзлийг нурааж өөрчлөлт хийх бололцоог "уран баримал" олгоно.

В.Сатирын сэтгэл заслын үйл ажиллагааг нарийн үе шатанд хуваахад хүндрэлтэй байдаг. Гэр бүлийн түүхийг бүтээх үе болон эрчимтэй үйл ажиллагааны үе хэмээн ерөнхийд нь ангилж болох юм. Эрчимтэй үйл ажиллагааны үед гэр бүлийн хуучин харилцааг халж, гэр бүлийн гишүүдийг сэтгэл догдлолд оруулснаар тэвчээр барагдсан хүмүүс сэтгэлийн хөөрлөө ил гарган гэр бүлийн бүтцийг өөрчлөх түлхэц болж өгдөг.

Ж.Белл гэр бүлийн асуудлыг шийдвэрлэхэд уйгагүй сууж, гэр бүлд таатай орчинг бүрдүүлэн гэр бүлийн аль ч гишүүнийг эвгүй байдалд оруулахгүйгээр ажилладаг бол В.Сатир зарчмын гурван мэдлэг дээр тулгуурлан ажилладаг. Үүнд: 1. бидний өнөөдрийн асуудал бол урьд үеийнхний маань үйл явдлын үр дүн; 2. бид бүгд нягт харилцаа холбоотой; 3. бид сайн сайхан өөрчлөлт хийх чадвартай.

Р.Спек, Ж.Бинг-Холл, С.Минучин зэрэг сэтгэл засалчид гэр бүлтэй өөр өөрийн арга барил, хэрэгсэлтэй байсан хэдий ч бүгд үр дүнтэй ажиллаж байв. Үр дүнтэй үйл ажиллагаа нь тодорхой арга

техникээс шалтгаалахын зэрэгцээ нийгмийн ажилтан, сэтгэл засалчдын ажлын үндсэн зарчим, байр суурь болон итгэл үнэмшлээс хамаарна.

Гэр бүлтэй ажиллах нийгмийн ажил дахь гэр бүлд суурилсан сэтгэл заслын үйлчилгээ нь гэр бүлийн гишүүдийг тус тусад нь салангид биш бүх гишүүдэд чиглэсэн халамж, туслалцаа үзүүлэх мэргэжлийн үйлчилгээ юм.

Гэр бүлийн хамтын сэтгэл заслын үндэс нь гэр бүлийн нийгэм- сэтгэл зүйн асуудал болон түүнийг шийдвэрлэхэд гэр бүлийг нэгдмэл цогц зүйл хэмээн үзэх явдал юм. Гэр бүлийн асуудлыг үл шийдвэрлэснээр нэг талаас, гэр бүлийн нэгдмэл байдалд цав гаргах, нөгөө талаас, гишүүдийн хувийн зан чанарт өөрчлөлт оруулах хор хөнөөлтэй. Гэр бүлд суурилсан хамтын сэтгэл заслын үйлчилгээг гэр бүл бүхэлд нь чиглүүлж ажилласнаар гэр бүл эрүүл саруул оршин тогтнох үндсийг бэхжүүлж, гишүүдийн хоорондын харилцааг илүү нээлттэй болгож чадна. Энэхүү өгүүлэлдээ гэр бүлийн хамтын сэтгэл заслын зорилго зорилт, үндсэн зарчим, онцлог болон үйл ажиллагааны үе шатыг дэлгэрэнгүй авч үзлээ.